



VII-IX/2021


Тархаасан: 2021 оны 11 дүгээр сарын 15



Өрхийн сарын дундаж бодит нийт орлого өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар буурлаа

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2021 оны 3 дугаар улирлын дүнгээр өрхийн сарын дундаж нийт орлого, оны үнээр 1.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 123.7 (8.2%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 93.5 (6.1%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

ЗУРАГ 1. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр



Нэг өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт орлогын хэмжээ 2021 оны 3 дугаар улиралд 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.8 (1.3%) мянган төгрөгөөр буурч, харин өмнөх улирлаас 46.2 (4.0%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Бодит нийт орлогын хэмжээ өмнөх улирлаас 4.0 хувиар нэмэгдэхэд цалин хөлсний бодит орлого 51.7 (10.6%) мянган төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ (Зураг 1).


ХҮСНЭГТ 1. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, оны үнээр

Орлогын төрөл	2020 VII-IX	2021		2021 VII-IX	2021 VII-IX
		IV-VI	VII-IX	2020 VII-IX	2021 IV-VI
	төгрөг			хувь	
Нийт орлого	1 512 688	1 542 867	1 636 403	108.2	106.1
1. Мөнгөн орлого	1 396 196	1 434 595	1 510 418	108.2	105.3
Цалин хөлс	774 175	650 458	733 815	94.8	112.8
Тэтгэвэр, тэтгэмж	304 103	461 989	461 675	151.8	99.9
ХАА-н үйлдвэрлэлийн орлого	106 712	132 126	133 734	125.3	101.2
ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	86 654	76 078	73 863	85.2	97.1
Бусад орлого	124 552	113 944	107 331	86.2	94.2
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	50 266	36 662	40 377	80.3	110.1
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	66 226	71 610	85 608	129.3	119.5

Өрхийн сарын дундаж мөнгөн орлого, оны үнээр 2021 оны 3 дугаар улиралд 1.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 114.2 (8.2%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Үүнд тэтгэвэр, тэтгэмжийн орлого 157.6 (51.8%) мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 27.0

(25.3%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн орлого өмнөх улирлаас 75.8 (5.3%) мянган төгрөгөөр нэмэгдэхэд цалин хөлсний орлого 83.4 (12.8%) мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ (Хүснэгт 1).

ЗУРАГ 2. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, 2021 оны 3 дугаар улирлын байдлаар, улсын дунджаар



Өрхийн сарын дундаж мөнгөн орлогод цалин хөлсний орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 6.9 нэгж хувиар, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувь 1.3 нэгж хувиар, бусад орлогын эзлэх хувь 1.8 нэгж хувиар буурч, харин тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 8.8 нэгж хувиар, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлогын эзлэх хувь 1.2 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 2).

Өрхүүдийг мөнгөн орлогоор нь бүлэглэн авч үзэхэд 2021 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 300.0 мянган төгрөгөөс доош орлоготой өрх 20.4 мянгаар, 300.0-500.0 мянган төгрөгийн орлоготой өрх 14.2 мянгаар, 500.0-700.0 мянган төгрөгийн орлоготой өрх 6.0 мянгаар, 700.0-900.0 мянган төгрөгийн орлоготой өрх 5.0 мянгаар, 900.0-1100.0 мянган төгрөгийн орлоготой өрх 4.0 мянгаар буурсан бол 1.1-1.6 сая төгрөгийн орлоготой өрх 15.5 мянгаар, 1.6-2.1 сая төгрөгийн орлоготой өрх 11.1 мянгаар, 2.1-3.0 сая төгрөгийн орлоготой өрх 34.3 мянгаар, 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой өрх 1.8 мянгаар тус тус нэмэгдсэн байна (Хүснэгт 2).

ХҮСНЭГТ 2. МӨНГӨН ОРЛОГЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн дүнд эзлэх хувь, мянган өрхөөр

Мөнгөн орлогын бүлэг	2020 VII-IX		2021 IV-VI		2021 VII-IX	
	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь
300 000 төгрөг хүртэл	36.9	4.1	21.9	2.4	16.5	1.8
300 001 - 500 000	97.3	10.8	88.4	9.7	83.1	9.1
500 001 - 700 000	86.4	9.6	83.8	9.2	80.4	8.8
700 001 - 900 000	97.3	10.8	113.9	12.5	92.3	10.1
900 001 - 1 100 000	102.7	11.4	92.9	10.2	98.7	10.8
1 100 001 - 1 600 000	185.5	20.6	207.7	22.8	201.0	22.0
1 600 001 - 2 100 000	133.3	14.8	130.3	14.3	144.4	15.8
2 100 001 - 3 000 000	100.0	11.1	109.3	12.0	134.3	14.7
3 000 001 төгрөгөөс дээш	61.2	6.8	62.8	6.9	63.0	6.9

Улсын хэмжээнд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар сард 500.0-900.0 мянган төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлогын 61.3 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 13.3 нэгж хувиар нэмэгдсэн байна.


ХҮСНЭГТ 3. МӨНГӨН ОРЛОГЫН БҮЛЭГЛЭЛТ, төгрөгөөр

Мөнгөн орлогын бүлэг	Мөнгөн орлогын бүлэг						
	Дундаж мөнгөн орлого	Цалин хөлс	Тэтгэвэр, тэтгэмж	ХАА-н үйлдвэрлэлийн орлого	ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Бусад орлого	
2020 VII-IX	500 000 төгрөг хүртэл	341 942	43 899	214 300	55 173	7 414	21 156
	500 001 - 900 000	707 174	192 963	339 727	92 048	29 763	52 673
	900 001 - 1 600 000	1 219 575	648 942	313 772	104 400	68 878	83 583
	1 600 001 төгрөгөөс дээш	2 479 716	1 592 449	313 308	141 616	175 686	256 657
2021 VII-IX	500 000 төгрөг хүртэл	379 347	24 283	283 937	43 500	3 153	24 474
	500 001 - 900 000	705 102	122 136	432 485	95 067	7 597	47 817
	900 001 - 1 600 000	1 226 759	498 379	493 000	122 313	55 674	57 393
	1 600 001 төгрөгөөс дээш	2 499 559	1 458 704	501 178	189 856	144 158	205 663

Судалгааны 2021 оны 3 дугаар улирлын дүнгээр өрхийн сарын дундаж нийт зарлага, оны үнээр 1.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 37.2 (2.4%) мянган төгрөгөөр буурч, харин өмнөх улирлаас 18.4 (1.2%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

ЗУРАГ 3. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр

- Өрхийн сарын дундаж нийт зарлага, оны үнээр
- Өрхийн сарын дундаж нийт зарлага, 2015 оны зэрэгцүүлэх үнээр




Нэг өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт зарлагын хэмжээ 2021 оны 3 дугаар улиралд 1.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 135.2 (11.0%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 8.0 (0.7%) мянган төгрөгөөр буурчээ. Бодит нийт зарлагын хэмжээ өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар буурахад хүнсний бус бараа, үйлчилгээний бодит зарлага 101.7 (13.1%) мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ (Зураг 3).

Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага, оны үнээр 2021 оны 3 дугаар улиралд 1.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 46.6 (3.3%) мянган төгрөгөөр буурсан байна. Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага өмнөх оны мөн үеэс буурахад хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 45.8 (4.7%) мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 4).

ХҮСНЭГТ 4. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, оны үнээр

Зарлагын төрөл	2020 VII-IX	2021		2021 VII-IX	2021 VII-IX
		IV-VI	VII-IX	2020 VII-IX	2021 IV-VI
	төгрөг			хувь	
Нийт зарлага	1 531 898	1 476 318	1 494 744	97.6	101.2
1. Мөнгөн зарлага	1 415 406	1 368 046	1 368 759	96.7	100.1
Хүнсний бүтээгдэхүүний зарлага	306 461	339 642	310 784	101.4	91.5
Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	966 066	892 959	920 225	95.3	103.1
Бусад зарлага	116 611	111 798	108 654	93.2	97.2
Бусдад өгсөн бэлэг, тусламж	26 268	23 647	29 096	110.8	123.0
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	50 266	36 662	40 377	80.3	110.1
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	66 226	71 610	85 608	129.3	119.5

ЗУРАГ 4. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, 2021 оны 3 дугаар улирлын байдлаар, улсын дунджаар



Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагад хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын эзлэх хувь 2021 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар, бусад зарлагын эзлэх хувь 0.2 нэгж хувиар буурч, харин хүнсний бүтээгдэхүүний зарлагын эзлэх хувь 1.1 нэгж хувиар, бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлагын эзлэх хувь 0.2 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 4).

Өрхийн хүнсний бүтээгдэхүүний сарын дундаж зарлагын 36.0 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 23.3 хувийг үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн, 11.4 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, 8.0 хувийг хүнсний ногоо, булцуут, навчит ургамал, 3.5 хувийг элсэн чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн, амттан эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, гол нэр төрлөөр, төгрөгөөр

Хүнсний бүтээгдэхүүний гол нэр төрөл	2020 VII-IX	2021 IV-VI	2021 VII-IX
Мах, махан бүтээгдэхүүн	103 989	125 301	111 735
Үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн	72 927	77 333	72 325
Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	31 412	41 421	35 499
Хүнсний ногоо, булцуут, навчит ургамал	24 331	26 580	24 778
Элсэн чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн, амттан	14 128	12 550	11 011
Жимс, самар	9 451	12 378	10 958
Цэвэр ус, ундаа, жимсний шүүс	12 660	10 693	10 039
Төрөл бүрийн өөх, тос	7 319	8 128	8 439
Цай, кофе	4 609	5 672	4 898

Мөн хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын 11.9 хувийг бэлэн хувцас, гутал, 9.5 хувийг тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар, үйлчилгээ, 6.2 хувийг харилцаа холбооны үйлчилгээ, 5.7 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээний зардал, 5.3 хувийг боловсролын зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 6. ХҮНСНИЙ БУС БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, гол нэр төрлөөр, төгрөгөөр

Нэр төрөл	2020 VII-IX	2021 IV-VI	2021 VII-IX
Тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар	65 732	67 488	75 181
Бэлэн хувцас	74 399	68 850	71 603
Харилцаа холбооны үйлчилгээ	50 820	53 941	57 143
Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээ	47 722	53 106	52 832
Боловсрол	43 094	45 477	49 155
Гутал, хос	38 571	36 001	37 849
Түлш	26 443	26 091	25 208
Чөлөөт цаг болон соёлын үйлчилгээ	23 987	24 101	24 603
Сууцны төлбөр	27 974	23 941	22 738
Тээврийн үйлчилгээ	18 496	11 337	12 236
Цахилгаан	25 824	15 504	9 305

Өрхүүдийг мөнгөн зарлагаар нь бүлэглэн авч үзэхэд 2021 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 300.0 мянган төгрөгөөс доош зарлагатай өрх 2.3 мянгаар, 700.0-900.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 8.4 мянгаар, 2.1-3.0 сая төгрөгийн зарлагатай өрх 1.4 мянгаар, 3.0 сая төгрөгөөс дээш зарлагатай өрх 15.4 мянгаар буурсан бол, 300.0-500.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 9.4 мянгаар, 500.0-700.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 13.2 мянгаар, 900.0-1100.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 10.5 мянгаар, 1.1-1.6 сая төгрөгийн зарлагатай өрх 5.7 мянгаар, 1.6-2.1 сая төгрөгийн зарлагатай өрх 1.8 мянгаар тус тус нэмэгдсэн байна (Хүснэгт 7).

ХҮСНЭГТ 7. МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн дүнд эзлэх хувь, мянган өрхөөр

Мөнгөн зарлагын бүлэг	2020 VII-IX		2021 IV-VI		2021 VII-IX	
	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь
300 000 төгрөг хүртэл	27.0	3.0	28.2	3.1	24.7	2.7
300 001 - 500 000	80.1	8.9	85.6	9.4	89.5	9.8
500 001 - 700 000	95.5	10.6	102.0	11.2	108.7	11.9
700 001 - 900 000	111.7	12.4	124.8	13.7	103.3	11.3
900 001 - 1 100 000	96.4	10.7	102.0	11.2	106.9	11.7
1 100 001 - 1 600 000	201.7	22.4	197.7	21.7	207.4	22.7
1 600 001 - 2 100 000	122.5	13.6	112.1	12.3	124.3	13.6
2 100 001 - 3 000 000	97.3	10.8	103.9	11.4	95.9	10.5
3 000 001 төгрөгөөс дээш	68.4	7.6	54.7	6.0	53.0	5.8

Сард 500.0-900.0 мянган төгрөг хүртэлх мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлагын бүтцийг авч үзэхэд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар дундаж зарлагын 30.6 хувийг хүнсний бүтээгдэхүүний зарлага эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 8. МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, төгрөгөөр

Мөнгөн зарлагын бүлэг	Дундаж мөнгөн зарлага	Хүнсний		Бусад зарлага	Бусдад өгсөн бэлэг, тусламж
		бүтээгдэхүүний зарлага	бус бараа, үйлчилгээний зарлага		
500 000 төгрөг хүртэл	364 163	116 428	181 558	60 206	5 971
2020 500 001 - 900 000	707 145	219 811	384 903	89 473	12 958
VII-X 900 001 - 1 600 000	1 224 565	311 731	776 034	114 275	22 525
1 600 001 төгрөгөөс дээш	2 538 863	436 911	1 893 688	160 511	47 753
500 000 төгрөг хүртэл	370 470	126 282	185 853	51 762	6 573
2021 500 001 - 900 000	700 875	214 779	382 669	86 127	17 300
VII-X 900 001 - 1 600 000	1 221 790	325 846	765 824	109 459	20 661
1 600 001 төгрөгөөс дээш	2 471 975	444 776	1 820 960	148 899	57 340

Ойлголт, тодорхойлолт

Өрх Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээт зүйлсээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүс болон ганц биеэрээ өрх болон амьдардаг хүнийг хэлнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн, хамаатан садны холбоотой, бүх гишүүд болон зарим гишүүд нь огт хамааралгүй эсвэл эдгээрийн аль алинаас бүрдсэн байж болно.

Өрхийн мөнгөн орлого Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого болон бусад орлогоос бүрдэнэ.

Өрхийн мөнгөн зарлага Хүнсний бүтээгдэхүүн, хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусдад өгсөн бэлэг, тусламж, бусад зарлага багтана.



Эх үүсвэр:

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 2 дугаар сарын 15

Нийгмийн статистикийн газрын
 дарга А.Амарбал
 Утас: (976-51)-264805

Нийгмийн статистикийн газрын
 Өрхөд суурилсан судалгааны
 хэлтсийн дарга М.Оюунцэцэг
 Утас: (976-51)-262325



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212